

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН-БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙДАД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 07 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Ж.Энхбаяр**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг томилуулах саналыг 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэгт заасныг баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдад нэр дэвшигч Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ нь 1990 онд Цэргийн дээд сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг тус тус төгссөн. Хуульч мэргэжилтэй.

Б.Бат-Эрдэнэ нь 1983-2000 онд Биеийн тамир спортын "Хүч" нийгэмлэгт тамирчин, орлогч дарга, дарга, 1999-2004 онд "Аварга" биеийн тамирын дээд сургуулийн захирал, 2004-2008, 2008-2012, 2012-2016 онуудад Монгол Улсын Их Хурлын гишүүнээр, 2009-2010 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргаар, 2016 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр Батлан хамгаалах яам нь ерөнхий чиг үүргийн яамны статустай болсныг анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн санал гаргалаа.


Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар томилуулах тухай Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг томилуулах саналын талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



УХА0316